



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/787

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдрийг угтсан болон тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардалд 2 310 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 2 310 000 /Хоёр сая гурван зуун арван мянган/ төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5.19-д тусгагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллыг дэмжих” хөтөлбөрийн зардлаас хавсралтын дагуу санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
11 дүгээр сарын 25-ны өдрийн
А/787 дугаар захирамжийн хавсралт



ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН
ӨДРИЙГ УГТСАН БОЛОН ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт /төг/
1	Спортын арга хэмжээний шагнал	45 хүн	20 000-30 000	1 510 000
2	Өдөрлөгийн арга хэмжээнд оролцогчдод цайны зардал	200	1000	200 000
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхчүүдийг чадавхижуулах сургалтын гарын авлага	100 хүн	3000	300 000
3	Дохионы хэлний орчуулга	1	100000	100 000
4	TV хэлэлцүүлгийн зардал	20 мин	10000	200 000
	Нийт			2 310 000